

Монголын бэлчээр түүний нөхөн сэргэх чадвар төслийн (MOR2) судалгааг өргөн дэлгэрүүлэх хамтын ажиллагааны хүрээнд Монголын хамтрагч байгууллагууд, сум орон нутгийн удирдлагууд, сургуулийн багш нартай хамтран боловсролын програм гаргах

Жамъяаншаравын Хишигбаяр

КМИС

# Судлах асуудлууд & Гол зорилго

## Судлах асуудлууд

- Нүүдлийн мал аж ахуй орших уу, эс орших?
- Өнөөгийн хувьсан өөрчлөгдөж байгаа нийгэм-байгаль цаг уурын нөхцөл байдал танай сумын ард иргэдийн хувьд хэрхэн мэдрэгдэж аж амьдралд нь хэрхэн нөлөөлж байна вэ?
- Нутаг бэлчээр цаашид ямар байдлаар сэргэн нөхөгдөх вэ?
- Малаа дагаж амьдардаг малчдын аж амьдрал өөрчлөлтөнд хэрхэн дасан зохицох вэ?

## Гол зорилго

- Өнөөгийн нийгэм, эдийн засаг, экологийн төрх байдлын хувьсан өөрчлөлтийг хамтарсан судалгаагаар дүгнэн баримтжуулж цаашид ирээдүй хойч үедээ мэдлэг мэдээлэл болгон үлдээх зорилготой.

# Гарах үр дүн

## 1. Сум орон нутгийн бэлчээрийн ном

- Орон нутгийн сургуулийн багш нар, мэргэжилтнүүдийг экологийн хээрийн судалгааны арга барилд сургах
- Орон нутгийн сурагчдын сургалтанд зориулсан тухайн нутгийн бэлчээрийн онцлогийг агуулсан ном бүтээн, хэвлүүлэх

## 2. Хамтран ажиллагч залуу судлаачдын мэдлэг чадварыг дээшлүүлэх

- Сургалт зохион байгуулах
- Цаашид зайнаас сургалт явуулах боломжийг тодорхойлох

## **Ашиглаж болох бэлэн байгаа мэдээллүүд**

- Фокус группуудын ярилцлага
- Сум, орон нутгийн бүлгийн ярилцлага асуулгууд
- Сумын статистикийн мэдээлэл

## **Багш нарын цуглуулах мэдээлэл**

- Нутгийнхаа малчдаас насны бүлэглэлээр ярилцлага асуулга явуулж мэдээлэл цуглуулна
- Дүгнэлт хураангуйг бичнэ
- Голлох ургамлын болон түүхэн зурагнуудыг цуглуулах

**MOR 2 төслийн хүрээнд цуглуулсан өгөгдлүүдийг багш нарын цуглуулсан мэдээлэлтэй холбон нэгтгэн дүгнэж оруулна.**

# Сум орон нутгийн бэлчээрийн ном

- **1-р бүлэг:** Сумын түүхэн болон жилийн 4 улирлын тухай мэдээлэл
  - Сумын түүхэн үйл явдлууд тухайлбал бэлчээр, байгалийн нөөцийг хэрхэн ашиглаж ирсэн туршлага, мөн түүнчлэн нэгдлийн үеэс ардчиллын үед гарсан нийгмийн болон экологи, эдийн засгийн өөрчлөлтүүдийн талаар 61-аас дээш насны, 46-60 насны, 31-45 болон 16-30 насны залуу малчдаас ярилцлага судалгаа аван энэ бүлэгт дүгнэж оруулна.
  - Энэ хэсэгт мөн чухал онцлох цаг уурын үзүүлэлтүүдийн үзүүлсэн нөлөөг малчдаас асууж тодруулахын зэрэгцээгээр үүнтэй холбоотойгоор гарсан улирлын хугацааны өөрчлөлтүүдийг тэмдэглэнэ.

# Сум орон нутгийн бэлчээрийн ном

- **2-р бүлэг:** Хил хязгаарын тухай малчдын нүүдлийн хурээ хязгаарын талаарх газрын зураг
- Сумын малчдын группээр болон хот айлаараа нүүдэллэх нүүдлийн хил хязгаар алслалтын талаар малчдаас өөрсдөөс нь судалгаа аван гар зургаар бүдүүвч гаргах,
- 2009-2010 он болон 2011-2012 оны нүүдэллэсэн байдалд үндэслэх
- КМИС-ийн судлаачид эдгээр мэдээллийг ашиглан ГМС технологийг ашиглан компьютерээр боловсруулсан газрын зургийг бүрдүүлж өгнө

# Сум орон нутгийн бэлчээрийн ном

- **3-р бүлэг:** Нөхөн сэргэх чадвар,
- Малчдын олон жилийн бэлчээрийн туршлага, мэдлэг, бэлчээрийн нөөц, ургамлын ургац, зонхилох ургамлын бүтцэд гарч буй өөрчлөлтүүд, бэлчээрийн нөхцөл байдалд гарч буй өөрчлөлтийн талаарх санал бодол
- Малчдын малаа маллаж ирсэн туршлага, цаашид залуу үеийнхэнд зөвлөх зөвлөлгөө
- Мал сүргийн бүтцийн өөрчлөлт, түүний бэлчээрт үзүүлэх нөлөө
- Мал маллах менежментийн өөрчлөлтүүд: тухайлбал өвс хадах, нүүдэл бэлчээр сэлгэх, мал эмнэлгийн үйлчилгээ, эрлийзжүүлэлт, малчдын бүлэг, өөр бусад байгуулагуудтай хамтран ажилласан туршлагууд

# Сум орон нутгийн бэлчээрийн ном

- 4-р бүлэг: Экологийн хээрийн судалгаа болон нийгмийн судалгааны дүгнэлтүүд
- Зуны экологийн хээрийн судалгааны, тухайлбал биомассын гарц ургамлын бүлэглэлээр, ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, ургамлын бүрхэц, хөрсний бүтэц зэрэг үр дүнгүүд
- Нийгмийн судалгааны айл өрхийн болон бүлэг группын судалгааны үр дүнгийн тойм



# Сум орон нутгийн бэлчээрийн ном

- **5-р бүлэг:** Цаг уурын үндсэн мэдээллүүд
- Хур тунадас, температурын өөрчлөлт, хэмнэл, хандлага
- Гол горхи усны, ус зүйн горим, урсац зэрэг үзүүлэлтүүдэд гарч буй өөрчлөлтүүд
- Цаг уурын гамшигт үзэгдлүүдийн давтагдал
- **Дүгнэлт**
- Нөхөн сэргэх болон дасан зохицох чадварыг бүрдүүлэх

# Сум орон нутгийн бэлчээрийн ном

- **Хэрэгжүүлэх хугацаа**

- Асуулга судалгааг 2012 оны 8 сарын 15ны дотор нийлүүлнэ.
- Фото зураг бусад дугнэж бичигдсэн бүтээгдэхүүнийг 10 сарын нэгний дотор нийлүүлнэ.
- Эцсийн бүтээгдэхүүнийг 12 сарын 15-ны дотор нийлүүлнэ.
- Номын эхний хувилбарыг сумдын бусад удирдах хүмүүс болон нийгмийн төлөөлөгчдөөр 2012 оны 3 сард хэлэлцүүлнэ.
- Хэлэлцүүлгээс гарсан санал шүүмжийг тусгаад хэвлэлтэнд 2012 оны 6 сард өгнө.

- **Хэнд зориулагдах болон хэрэглэгдэх**

- 6-11-р ангийн хүүхдүүдэд
- Малчин залуучуудад
- Нийт сумын иргэд

# Хамтран ажиллагч залуу судлаачдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах

- Энэ зун явагдах боломжтой сургалтууд:
  - Нийгмийн судалгааны арга загварчлалтай танилцах, аксес датабэйстэй танилцах мөн дадлага хийх өгөгдөл оруулах болон тухайн өгөгдлийг ашиглах төсөл бичих - Тунгалаг
  - ГБМ-ийн сургалт (экологийн сургалтын үеэр явагдана) - Мелинда
  - Цаг уурын өгөгдлийг боловсруулах, экселийн анализ хийх үйлдэл, функцуудыг судлах - Ниа, Хишигбаяр
- Цаашид зайнаас сургалт явуулах хэрэгцээ, сонирхол, боломж

**Асуулт, санал?**

